



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/594

Арвайхээр

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
сунгах тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны 257 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын 9 дүгээр цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл, Хархорин сумын 5 дугаар цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 09 дүгээр сарын 16-ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл тус тус 5 жилийн хугацаатай сунгасугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл сунгагдсан дээрх байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101091